

Иргэний нисэхийн албадан хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн орчны харьцуулалт

Шинэ-Зеланд Улс

Монгол Улс

NZ Aviation Crimes Act 1972:

Шинэ-Зеландын Нисэхийн эрүүгийн хуульд дараах ял, шийтгэлийг оногдуулдаг. Үүнд:

- 10 үйлдэлд хорих (2 жил, 5 зүйл ангид бүх насаар);

Эрүүгийн хууль 2015: (₮ 40 сая)

Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой **нийт 16** үйлдэлд дараах ял, шийтгэлийг оногдуулдаг. Үүнд:

- Үүнээс 14 үйлдэлд хорих - 6 сараас 20 жил;
 9 үйлдэлд нэмж зорчих эрхийг хязгаарлах - 1 сараас 5 жил;
 12 үйлдэлд нэмж торгох - \$160 - \$14 000.

NZ Civil Aviation Act 1990:

- 18 үйлдэлд хорих (3 сараас 2 жил хүртэл);
- Үнэмлэх гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 70 гаруй үйлдэлд торгох - хувь хүнийг \$1 000 - \$200 000,
 - хуулийн этгээдийг \$10 000 - \$200 000.

Иргэний нисэхийн тухай хууль 2023:

10.2.8. Дарга хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авах;

51.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд үйлдлийн шинж чанараас хамааран Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

NZ Civil Aviation (Offences) Regulations 2006:

- 1670 дүрмийн заалтаар торгох - хувь хүнийг \$150 - \$1 200,
 - хуулийн этгээдийг \$900 - \$7 200.

Тайлбар: Үнэмлэх гэрчилгээнд авах арга хэмжээ ороогүй.

ИНД-13 Албадан хэрэгжүүлэх дүрэм (Төсөл):

ИНТХ-ийн 10.2.8-ын дагуу нийт 51 бүлгийн 273 төрлийн зөрчилд авах арга хэмжээг тодорхойлсон. Үүнд:

- 1645 дүрмийн заалтаар торгох - хувь хүнийг \$28 - \$570,
 - хуулийн этгээдийг \$200 - \$3 500.
- Дарга дараах 8 нөхцөлд үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлж, хүчингүй болгох:
 - хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан;
 - нисэхийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн;
 - эрх бүхий байцаагчид үзлэг шалгалт хийхэд саад болсон, эсхүл татгалзсан;
 - хайхрамжгүй, санаатай үйлдсэн аливаа зөрчил;
 - баримт бичиг, бүртгэлийг хуурамчаар үйлдсэн, эсхүл засварласан;
 - согтууруулах ундаа, мансууруулах бодис, эсхүл сэргээш хэрэглэсэн;
 - үнэмлэх, гэрчилгээгээр олгосон эрх, зөвшөөрлийг хэтрүүлсэн;
 - үр дагавар нь эдийн засгийн ихээхэн хохиролтой зөрчил үйлдсэн.

NZ Civil Aviation Act болон NZ Civil Aviation (Offences) Regulations-ээр зохицуулдаг.

Зөрчлийн тухай хууль 2017

Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой **нийт 10** зөрчилд дараах шийтгэлийг оногдуулдаг. Үүнд:

- 10 зөрчилд торгох - хүнийг ₮10,000 - 20 сая (\$3 - \$5,700),
 - хуулийн этгээдийг ₮100,000 - 200 сая (\$28 - \$57,000);
- 3 зөрчилд эрх хасах - 1 жил хүртэл.